

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Үндэсний аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн
ажил үйлчилгээний төлөвлөгөө, нэгдсэн удирдамжийн
дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН”



Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн
зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Агуулга.....1
	Товчилсон үгийн жагсаалт.....2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....3-4
ААГ-ын НА-ын баг	БҮЛЭГ-1
Газрын дарга, тэргүүлэх аудитор	1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлсэн байна.....5
Ч.Чүлтэмбат	1.2. Аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу хуваарилж, олгоогүй байна.....6
Аудитын менежер	1.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.....7
Ш.Мөнхбаяр	1.4. Аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгасан ХО-ын ажлуудын 97.4 хувь нь хэрэгжсэн байна.....8
Ахлах аудитор	1.5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.....10
Х.Сувдмаа	1.6. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хууль болон “ОНХС-аас олгор орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-тай нийцэж байна.....10
Аудитор	1.7. Төсөл хөтөлбөрт ДХББЗГ ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг хийж, санхүүжилтийг олгосон байна.....11
Г.Батмягмар	1.8. Аймаг, сумдын ИТХ нь ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
	1.9. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ОНХС-ийн зааврын дагуу орон нутгийн өмчид бүртгэсэн байна.....11
2018 оны 11 дүгээр сар	БҮЛЭГ-2
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7037-3089, 7037-8845 дугаарын утсаар харилцана уу.	2.1. Тайлант онд СХС-ийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлсэн байна.....12
	2.2. СХС-ийн хөрөнгийн 19.1 хувийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.....13
	2.3. СХС-аас төсөл хэрэгжүүлсэн үр дүнд баталгаатай ажлын байр бий болж чадахгүй байна.....14
	2.4. СХС-ийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгээгүй байна.....17
	2.5. СХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын зарим заалтыг нарийвчлан тусгаж тодорхой болгох шаардлагатай байна.....18
ХАЯГ:	БҮЛЭГ-3
Дархан-Уул аймгийн Дархан сум 14-р баг Аймгийн ЗДТГ-ын байр 306, 307 тоот Төрийн аудитын газар	3.1. Өмнөх оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.....19
	3.2. Өмнөх оны СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж хэрэгжсэн байна.....19
	БҮЛЭГ-4
	4.1. ДҮГНЭЛТ.....20
	4.2. ЗӨВЛӨМЖ.....21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ХАА	Худалдан авах ажиллагаа
ДХББЗГ	Дархан хот-байгуулалт, барилга захиалагчийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
МУ	Монгол Улс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЗД	Засаг дарга
СХСХБЗТХТЖ	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов А/06 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт 2017 оны төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, дүгнэлт гарган дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- *Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх*
- *Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх*
- *Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, ОНХНС, ОНХС-ийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв, төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн СХС-ийн орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагнал зэргийг авч үзэв.

Арга зүй:

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитыг горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30-р тогтоол
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 153-р тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн ИТХ нь төсөвт 3 удаа тодотгол хийсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 9/05 тоот тогтоолоор оны эхний үлдэгдэл 798.0 сая төгрөг дээр ОНХНС-ийн шилжүүлэг 671.0 сая, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 299.1 сая төгрөгийг тус тус нэмж, улсын төсвийн тодотголоор хасагдсан 173.1 сая төгрөгийг хасаж, 1,595.1 сая төгрөгөөр баталжээ.

2017 онд шинэ болон шилжих хөрөнгө оруулалтаар нийт 114 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 111 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд 3 суманд 68 төслийг хэрэгжүүлэхээр 570.6 сая төгрөгийн зээлийг олгожээ.

БҮЛЭГ 1

ОНХС-гийн хөрөнгийг Төсвийн тухай хуулийн дагуу хуваарилаагүй байна.

НЭГ. АУДИТЫН ДҮН

1.1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж бүрдүүлсэн байна.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг анх 1,946.4 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” аргачлалд үндэслэн 30 хувь буюу 201.2 сая төгрөгийг сумын ОНХС-д, 70 хувь буюу 469.8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д олгохоор төлөвлөжээ.

Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалан УИХ-аас Монгол Улсын 2017 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай хуулиар аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 1,773.3 сая т-өгрөг буюу 173.1 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Энэ нь “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” аргачлалын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх “Энэ аргачлалын 2.2.1¹ -д заасан эх үүсвэрийг сум, дүүргийн хөгжлийн санд хуваарилахад Төсвийн тухай хуулийн 59.2-т заасныг мөрдлөг болгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХ нь төсөвт 3 удаа тодотгол хийсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 9/05 тоот тогтоолоор оны эхний үлдэгдэл 798.0 сая төгрөг дээр ОНХНС-ийн шилжүүлэг 671.0 сая, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 299.1 сая төгрөгийг тус тус нэмж, улсын төсвийн тодотголоор хасагдсан 173.1 сая төгрөгийг хасаж, 1,595.1 сая төгрөгөөр баталжээ.

Уг орлогын шилжүүлгийг аймаг, сумдад олгохоор төлөвлөхдөө сумдад 57.5 хувь буюу 917.2 сая төгрөгийг, аймагт 42.5 хувь буюу 677.9 сая төгрөгийг тооцож төлөвлөсөн байна.

Аймаг, сумд ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасан дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

1. ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлэг 943.7 сая төгрөг.
2. Аймаг сумын үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг 1,275.3 сая төгрөг.
3. Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж 352,3 сая төгрөг.
4. Бусад орлого 296.6 сая төгрөг.

Аймаг, сумд ОНХС-гийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан нэр, төрөл тус бүрээр бүрдүүлсэн байна. Үүнд:

¹ 2.1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг

ОНХС-д төвлөрүүлсэн эх үүсвэрийн судалгаа

/сая төгрөг/

Нийт эх үүсвэрийн гүйцэтгэл

№	Нэрс	ОНХНС-аас олгох шилжүүлэг	Урьд оны үлдэгдэл	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр	Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгор олгосон дотоод, гадаадын хандив	Бусад орлого	Нийт эх үүсвэр
1	Аймаг	856.1	798.0			296.6	1 950,7
2	Сум	564.9			352.3		1 269,5
	Дүн	1 421,0	798.0	0	352.3	296.6	2 867,9

Дээрх хүснэгтээс үзэхэд аймаг, сумд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэрээс бусад төрлийн эх үүсвэрээс төвлөрүүлжээ.

ОНХНС-аас олгохоор тооцсон нийт 1,773.3 сая төгрөгийн эх үүсвэрийн 35.6 хувь буюу 630.6 сая төгрөгийг дотоодын НӨАТ-ын 5 хувь, 29.8 хувь буюу 528.7 сая төгрөгийг АМНАТ-ын 5 хувь, 14.8 хувь буюу 261.7 сая төгрөгийг газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30 хувь, 19.8 хувь буюу 352.3 сая төгрөгийг олон улсын байгууллагаас Дархан сумын ОНХС-д олгох урамшууллаас бүрдүүлсэн байна.

Аймгийн 2017 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 5/02 тоот тогтоолоор батлахдаа орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг сумдад 201.2 сая, аймагт 469.8 сая, нийт 671.0 сая төгрөг байхаар баталжээ.

Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 09/05 тоот тогтоолоор ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 1,773.3 сая, оны эхний үлдэгдэл 798.0 сая, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 299.1 сая, нийт 2,870.4 сая төгрөг байхаар тодотгожээ. Энэ нь ОНХНС-аас сумдын ОНХС-д олгох дүнгээс 716.0 сая, аймгийн ОНХС-д олгох дүнгээс 208.1 сая, нийт 924.1 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг тус тус нэмж баталсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

/Сая.төгрөг/

№	Үзүүлэлт	Оны эхний үлдэгдэл	Эхний батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү	Олгосон санхүүжилт
1	Аймгийн ОНХС	798.0	469.8	677.9	208.1	404.1
2	Дархан сум		68.3	696.5	628.2	521.3
3	Орхон сум		27.9	51.5	23.6	51.3
4	Шарын гол сум		42.8	66.6	23.8	66.6
5	Хонгор сум		62.2	102.6	40.4	83.1
	Нийт дүн	798.0	671.0	1,595.1	924.1	1,126.4

1.2 Аймгийн ОНХС-гаас олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу хуваарилж, олгоогүй байна.

Аймгийн ОНХС-гаас сумдад олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-д заасны дагуу баталжээ.

ОНХНС-гаас олгох аймаг болон сумдын ОНХС-гийн шилжүүлгийн төлөвлөгөө болон гүйцэтгэл

/ сая. төгрөг/

№	Нэрс	Олгох санхүүжилт	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн зөрүү
1	Дархан сум	696,5	521,3	175,2
2	Орхон сум	51,5	51,3	0,2
3	Шарын гол сум	66,6	66,6	
4	Хонгор сум	102,6	83,1	19,5
	Дүн	917,2	722,3	194,9

Хүснэгтээс үзэхэд ОНХНС-гаас олгосон шилжүүлгийг 21.3 хувь буюу 194.9 сая төгрөгөөр сумдад дутуу хуваарилж олгосон нь Төсвийн тухай хуулийн 59.2² дахь “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3³-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, ТАХ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр 2017 онд нийт 1,595.1 сая төгрөгийн 114 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар баталснаас урьд оны 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 208.5 сая төгрөг, тайлант оны 106 төсөл, арга хэмжээнд 1,386.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталжээ. Тайлант онд 1,536.0 сая төгрөгийн 113 төсөл, арга хэмжээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан нь Дархан хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, хөгжлийн цогц бодлого, чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан үйл ажиллагаатай уялдсан байна.

Төсвийн тухай хууль болон Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.2, 7.4 дэхь заалтаар аймаг, сумдын 2017 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гэрээ байгуулсан төсөл арга хэмжээг багцалж үзүүлбэл:

- 20.9 хувь буюу 290.9 сая төгрөгийг авто зам засвар, шинэчлэлт өргөтгөл, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч хийхэд
- 14.7 хувь буюу 204.6 сая төгрөгийг сумдын төвийн тохижилт, орон сууцны хороолол болон гэр хорооллын дунд хүүхдийн тоглоомын талбайн тохижилт, явган хүний замын ажил
- 9.3 хувь буюу 129.1 сая төгрөгийг гэр хорооллын гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, засвар шинэчлэлтийн ажилд
- 2.8 хувь буюу 39.8 сая төгрөгийг нийтийн орон сууцны гадна фасад шинэчлэлт болон инженерийн шугам шинэчлэлийн ажилд
- 0.4 хувь буюу 5.5 сая төгрөгийг ТЭЗҮ, зураг төсөв хийлгэхэд
- 3.3 хувь буюу 44.9 сая төгрөгийг үндэсний их баяр наадамд

² 59.2 Аймаг, нийслэл нь ОНХНС-гаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна.

³ 59.3 ОНХС-гаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно.

59.3.1 Орон нутгийн хөгжлийн индекс

59.3.2 Хүн амын тоо

59.3.3 Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ


59.3.4 Орон нутгийн татварын идэвх санаачлага.

- 48.6 хувь буюу 671.8 сая төгрөгийг хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6.6⁴-д заасны дагуу иргэдийн санал, ажлын хэсгийн санал дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг эрэмбэлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар хэлэлцүүлэг зохион байгуулжээ. Иргэдээс санал авах ажиллагаанд аймгийн хэмжээнд нийт 13749 иргэн хамрагдсан байна.

Аудитын төлөвлөгөөний 7 дугаар хавсралтаар ирүүлсэн маягтын дагуу 4 сумын 328 иргэнээс авсан санал асуулгын дүнг нэгтгэж үзэхэд 45 хувь ОНХС-ийн талаар тодорхой ойлголттой, багийн иргэдийн нийтийн хуралд идэвхитэй оролцож, саналаа өгдөг болсон байна.

Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.



Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр 2017 онд шинээр эхлүүлэх 1,386.6 сая төгрөгийн 106 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас харьцуулалтын аргаар 399.2 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ, шууд худалдан авалтын аргаар 987.4 сая төгрөгийн 96 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАУХАТухай хууль, түүнийг дагалдаж гарсан журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулжээ.

Дээрх графикаас харахад ихэнх ажлууд нь ШХА-ын аргаар зохион байгуулагдсан байв.

“Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинд нийтэлж, цахим хуудас болон Сангийн яамны “e-procurement.mof.gov.mn”, Дархан-Уул аймгийн Худалдан авах ажиллагааны албаны procurement.to.gov.mn сайт, байгууллагын мэдээ, мэдээллийн самбар, иргэний танхим дахь худалдан авах ажиллагааны албаны самбар, шилэн дансны сайт, аймгийн Darkhanuul.gov.mn сайтад тус тус байршуулан тендер оролцохыг сонирхогчдод тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор ханган мэдээллийг ил тод нээлттэй тавьж ажилласан байна.

1.4 Аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө оруулалтын ажлуудын 97.4 хувь нь хэрэгжсэн байна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 2017 онд 1,536.0 сая төгрөгийн 113 ТАХ-г хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан боловч “Бидний орчин-Миний оролцоо”

⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэд, олон нийтээс хамгийн их санал авсан, ажлын хэсгийн санал дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна.

төсөл дутуу, “Жимст цэцэрлэг”, Нийгмийн даатгалын хэлтсийн хуучин барилгыг худалдан авахаар төлөвлөгдсөн боловч орон нутгийн өмчид шилжүүлж авахтай холбоотойгоор Засгийн газрын тогтоол гарч шийдвэрлэгдэхгүй байсаар төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

ОНХС-гийн төсөл арга хэмжээг төлөвлөхдөө “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” баталсан журмын дагуу 05 дугаар сард багтаан багийн Засаг дарга нар БИНХ-аар урьдчилсан жагсаалтыг танилцуулж, иргэдийн саналыг авч баталгаажуулжээ.

Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээнд зарцуулах төсвийн хувь хэмжээг зааглаагүй, хөтөлбөр, төсөл арга хэмжээний нэршлийг тодорхой тусгаагүйгээс сангийн хөрөнгийг хөтөлбөр, төсөл арга хэмжээ нэрээр зориулалт бусаар зарцуулан, урсгал зардлуудыг санхүүжүүлж тус сангийн үр нөлөөг бууруулах, үр ашиггүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3⁵, 4.4⁶, 4.5⁷ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- 4.3-д “Төсвийн тухай хуулийн 60.3-д заасан ОНХС-гаас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчин “Ахмадын хороонд “Соён гэгээрүүлэх төсөл”-өөр 5.0 сая, Залуучуудын JCI байгууллагад “Инээмсэглэх Дархан төсөл”-өөр 3.0 сая, Аймгийн эмэгтэйчүүд холбоонд “Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын төв төсөл”-өөр 5.0 сая, Хүүхэд, залуучуудын соёлын оролцоо ТББ-д 7.5 сая, “Өег Дархан клуб” ТББ-д 4.0 сая, “Аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” 2.2 сая, “Гэрэл ган үзэг” ТББ-д 1.0 сая, “Сэтгэлийн ариун дэм” ТББ-д 2.0 төгрөг, МХБИБҮХолбоонд 5.0 сая, “Оюуны эрдэм хөтөч ТББ-д 5.0 сая, Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг ТББ-д 5.0 сая, Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд 3.0 сая, Цэргийн штабын дадлага сургалтын талбай байгуулахад 3.0 сая төгрөг
- 4.4-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалтуудыг зөрчин 7 дугаар багийн ИНХ байгуулах засварын ажилд 3.0 сая, 12 дугаар багийн камержуулалтад 9.9 сая, хаягжуулах ажилд 3.0 сая, 4-р багийн 34-р байранд мэдээллийн самбарт 3.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Түүнчлэн нийт төсөл, арга хэмжээний хөтөлбөр, төслөөр хийгдсэн ажлуудын 23.2 хувь нь хэт жижиглэж олгосон нь төсөл хэрэгжихгүй, хэрэгжүүлсэн төсөл үр дүнгүй болох нөхцлийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- “Бидний орчин-Миний оролцоо” 1.0 сая төгрөгийн төсөл дутуу, “Жимст цэцэрлэг” 5.0 сая, нийт 6.0 сая төгрөгийн төсөл хэрэгжээгүй.
- “Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын төв төсөл”-ийн 5.0 сая төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, үйл ажиллагаа явуулаагүй.
- Ахмадын хорооны “Соён гэгээрүүлэх төсөл”-ийн 2.5 сая төгрөгийг зарцуулсан анхан шатны баримт хангалтгүй, төсөл хэрэгжсэн нь тодорхойгүй

⁵ Төсвийн тухай хуулийн 60.3-д заасан ОНХС-гаас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх

⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх

⁷ “Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-гаас хөрөнгө зарцуулахгүй байх”

- “Идэвхитэй хөдөлгөөн эрүүл мэнд ” 3.0 сая төгрөгийн төсөл хаана, хэрхэн хэрэгжих, хэрэгжсэн нь тодорхой бус анхан шатны баримтгүй
- Оюуны эрдэм хөтөч ТББ-ын 5.0 сая төгрөгийн “Багш нарын мэргэжил дээшлүүлэх төсөл” холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу
- Дархан сумын 1-р сургуульд “Хүнсний технологи кабинет” төслөөр “Next электроникс” цахилгаан барааны дэлгүүрээс булан тохой нь эмтэрсэн гал тогооны тавилга нийлүүлсэн бөгөөд хүлээн авсан комисс одоог хүртэл ямар ч арга хэмжээ аваагүй байсныг аудитын явцад тавилгыг сольж шинийг авсан.

Засаг даргын төсөл, хөтөлбөрөөр хийгдсэн ажлын хөрөнгө шаардлага хангахгүй, ашиглагдахгүй, хөрөнгийн хамгаалалт муу эвдэрсэн байдалтай байна.

- Дархан сумын Малчин багт 15.0 сая төгрөгөөр худаг барьж өгсөн ч худгийг одоог хүртэл ашиглаагүй.
- Ашиглалтын зардлыг шийдвэрлээгүй хөрөнгө төлөвлөснөөс Дархан сумын 12 дугаар багт хэрэгжих 10.0 сая төгрөгийн “Камержуулалт-2” төсөл хэрэгжээгүй
- Аймгийн Цагдаагийн газрын 18 хэсгийн байцаагчдад авч өгсөн энгэрийн камерийн 80 хувь нь ажиллахгүй, үзүүлэлт бага, хэрэглэхэд төвөгтэй, мөн шаардлага хангахгүй зөөврийн компьютер нийлүүлэгдсэн.
- “Миний гэр-Манай байр” төслийн хүрээнд 19.6 сая төгрөгөөр 14,16 дугаар багуудын орон сууцнуудад хийгдсэн кодтой хаалгын 80 хувь нь эвдэрсэн байна.

1.5 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний мэдээллийг зааврын дагуу мэдээлсэн байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3⁸-д заасны дагуу аймаг, сумын ИТХ-аар ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт, төсөвт өртгийг батлан гаргаж, байгууллагын ил тод мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулж иргэдэд танилцуулсан байна.

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн данс цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу аймаг болон сумын ОНХС-ийн шаардлагатай мэдээллүүдийг www.shilendans.gov.mn сайтад байршуулсан эсэхийг шалгахад Шилэн данс цахим хуудас болон Сангийн яамны www.mof.gov.mn вэб хуудасны “ОНХС” цэсэд аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг оруулсан байв.

Түүнчлэн төсвийн ил тод байдлыг хангах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс ОНХС-ийн талаарх мэдээллийг ил тодын самбар болон аймаг, сумын албан ёсны вэб сайтад байршуулах зэргээр хэрэгжүүлжээ.

1.6 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хууль болон “ОНХС-гаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-тай нийцэж байна.

ОНХС-гийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын

⁸ 11.2.3 “Аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчилж байна”

тухай хууль болон “ОНХС-гаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” зэрэг хууль тогтоомж, заавар журмууд мөрдөгдөж байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”, 60 дугаар зүйлд “Орон нутгийн хөгжлийн сан” гэж заасныг үндэслэж улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдах хөрөнгийг орон нутгийн түвшинд төлөвлөх, батлах, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавихаар “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” ашиглагдаж байна. Тус заавар нь Төсвийн тухай хууль болон “ОНХС-гаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-тай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолд улсын баяр наадмын санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10,0 сая, суманд 5,0 сая төгрөгөөр тогтоож, уг зардлыг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг тогтоосон.

Гэвч жил бүрийн улсын баяр наадмын зардалд аймаг 30,0 сая төгрөг батлуулан, зарцуулж байгаа нь дээрх тогтоолтой нийцэхгүй байна. Мөн өмнөх онуудад хийгдсэн нийцлийн аудитаар уг тогтоолыг хэрэгжүүлж ажил гэсэн зөвлөмж өгсөн боловч зөрчил давтагдсаар байна.

1.7 Төсөл, хөтөлбөрт “ДХББЗГ” ОНӨААТҮГ захиалагчийн хяналтыг хийж, санхүүжилтийг олгосон байна.

Монгол Улсын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1.6-д “бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтын дагуу “ДХББЗГ” ОНӨААТҮГ аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 1,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээнд захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

1.8 Аймаг, сумын ИТХ нь ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.17, 9.28 дахь заалтуудыг аймаг, сумдын ИТХ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дархан сумаас бусад сумдын ИТХ дэргэдээ Хяналтын хороо байгуулаагүй, 2017 оны ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймаг, сумын ИТХ хяналт тавьж ажиллаагүй зэрэг нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9 дүгээр зүйлийн 9.1⁹ дэх заалттай нийцэхгүй байна.

1.9 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ОНХС-ийн зааврын дагуу орон нутгийн өмчид бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 1521.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 111 төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6¹⁰ –д заасны дагуу НББ-д тусгасан байна.

⁹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

¹⁰ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ

БҮЛЭГ 2


Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн 76.5 хувийг журамд заасны дагуу зарцуулжээ

2.1. Тайлант онд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлсэн байна.

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23.1¹¹ дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134-р тогтоолыг үндэслэн Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/69, 2013 оны А/38 тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлттэй зээлээр дэмжих, тэдэнд бага хүүтэй банкны шаардлагаас гадуур зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор 2014 онд Дархан-Уул аймгийн 4 сумын Сум хөгжүүлэх санд нийт 209.3 сая төгрөг хуваарилжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3.1¹²-д заасны дагуу Дархан, Орхон, Шарын гол сумдууд ИТХ-аар сум хөгжүүлэх сангийн 2017 оны төсвийг батлуулсан боловч Хонгор сум төсвийг батлуулаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн 2016 оны эхний үлдэгдэл 1,768.7 сая төгрөг, тайлант онд 829.2 сая төгрөгийн орлого орсноос 94.2 хувь буюу 781.3 сая төгрөг нь зээл, 5.4 хувь буюу 44.6 сая төгрөг нь зээлийн хүү, 0.4 хувь буюу 3.3 сая төгрөг нь гэрээний дагуу алдангиас төвлөрсөн байна.



2017 онд нийт 68 зээлдэгчдэд 570.6 сая төгрөгийн зээл олгож, зээлийн хүүг бүрэн төвлөрүүлсэн байна.

Сумдын нэр	Тоо	Олгосон	Тооцсон зээлийн хүү	Төлөгдсөн хүү	Тооцсон хүүд эзлэх хувь
Дархан сум	34	337 950 000	4 874 232	4 736 355	97,17
Шарын гол сум	13	52 800 000			
Орхон сум	13	96 500 000	718 931	567 665	78,96
Хонгор сум	8	83 300 000	1 573 805	1 573 805	
Дүн	68	570 550 000	7 166 968	6 877 825	176

¹¹ Сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар сум хөгжүүлэх санд хөрөнгө хуваарилах

¹² 3.3. Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 3.3.1. сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;

2.2 Сангийн хөрөнгийн 19.1 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Сумдын СХС-д 2017 оны сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,748.8 сая төгрөг зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 829.2 сая төгрөг төвлөрч дахин хуваарилагдсан байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд 3 суманд 68 төслийг хэрэгжүүлэхээр 570.6 сая төгрөгийн зээлийг олгожээ.

МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3.1-д *“тухайн суманд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх”* гэж заасны дагуу сангийн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/118 тоот захирамжаар аймаг, сумдын ЖДҮ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг баталж өгсөн байна. Үүнд: фермерийн аж ахуй, сүү боловсруулах цех, хүлэмжийн, жимс жимсэний аж ахуй, ахуйн үйлчилгээний цэг, эсгийн үйлдвэр, төмөр хийцийн жижиг үйлдвэр, мод модон эдлэлийн цех, барилга барилгын материал түүхий эд үйлдвэрлэх төсөлд түлхүү олгох, тогтвортой ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллахаар Дархан сум 6, Орхон 4, Хонгор 8, Шарын гол 7 чиглэлийг тодорхойлжээ.

СХСХБЗТХТЖ-ын 3.3.1-д *“сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох”* гэж заасны дагуу Дархан сум 8.0-15.0 сая, Шарын гол сум 10.0-15.0 сая, Орхон сум 20.0 сая, Хонгор сум 2.5-10.0 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна. Дээрх сумдаас Хонгор сум харьцангуй багаар тогтоосон байв.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор болон 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан *“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”* –аар сангийн хөрөнгийг сумдад ЖДҮ шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна гэж заасан.

Мөн сумын Засаг даргыг “Сум хөгжүүлэх сан”-гийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн даргаар томилсон хэдий ч Дархан сумын Засаг дарга 2016 онд А/06, А/204, 2017 онд А/102 дугаар захирамжуудаар зөвлөлийн даргын бүрэн эрхийг сумын Засаг даргын орлогчид шилжүүлсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 3.3.3¹³-д заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

СХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг журмын 3.5.2-т заасны дагуу сумдын ИТХ-аас байгуулсан төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл нь сонгон шалгаруулсан төслийг сумын Засаг дарга захирамжлан гэрээ байгуулан олгожээ.

¹³ сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;

2.3 Сангаас төсөл хэрэгжүүлсэн үр дүнд баталгаатай ажлын байр бий болж чадахгүй байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.3.5-д “төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх” гэсэн шалгуур үзүүлэлтийг төсөлд огт тусгадаггүй байна. СХСХБЗТХТЖ-ын 4.3.6-д “ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх” шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч нар нь төсөлд ажлын байрыг нэмэгдүүлнэ, нийгмийн даатгалын шимтгэл төлнө гэх зэргээр хийсэн боловч аймгийн хэмжээнд сангаас төсөл хэрэгжүүлсэн үр дүнд бий болсон баталгаат ажлын байр ховор байна.

Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна гэсний дагуу зориулалтаар нь зарцуулсан иргэд байгаа хэдий ч, зээлийг аваад төсөл хэрэгжүүлээгүй, төслийн дагуу үйл ажиллагаагаа өргөжүүлээгүй, өөрийн хөрөнгө дутагдалтайгаас үйл ажиллагаа зогсонги байдалтай болж зээл төлөх чадваргүй, хугацаа хэтэрсэн зээлдэгчид бас байна. Иймд төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийн ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын явцад СХС-гаас олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхийг болон зээлийн эргэн төлөлтийг шалгахад төслийн сонгон шалгаруулалт, хяналт шалгалт хийгдсэн байдлаас шалтгаалан харилцан адилгүй хэрэгжилттэй байв. Үүнд:

- Дархан сумын иргэн М.Ууганбаяр 2017 онд 8.0 сая төгрөгөөр дугуй засвар байгуулах, Б.Батсуурь 7,9 сая, Ж.Эрдэнэчимэг 8.0 сая төгрөгөөр тус тус халуун усны газар байгуулах, С.Сүрэнжав 8.0 сая төгрөгөөр мах боловсруулах тасаг байгуулах
- Хонгор сумын иргэн Г.Чинноров 8.0 сая төгрөгөөр тавилга үйлдвэрлэх, Р.Алтантуяа 3.0 сая төгрөгөөр мах махан бүтээгдэхүүн худалдаалах, Б.Мөнхбаяр 7.0 сая төгрөгөөр фермер байгуулах, Б.Мөнхжаргал 4.0 сая төгрөгөөр оёдлын үйлдвэрлэл эрхлэх, Ш.Бат-Өлзий 10.0 сая төгрөгөөр гахайн аж ахуй эрхлэх
- Орхон сумын иргэн Д.Батдэлгэр 5.0 сая төгрөгөөр туслах аж ахуй эрхлэх төсөлд нийт 68.9 сая төгрөг авсан ч зээл хэрэгжээгүй хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байлаа.

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус Зөвлөл нь зээлдэгч нарын ирүүлсэн төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолох чадвар муу, иргэдийн төлбөрийн чадварыг нарийвчилан тодорхойлоогүйгээс ЖДҮ-ийн банкны зээлтэй, ОНХС-ийн хөтөлбөр, төсөлд хамрагдсан иргэдэд давхар зээл олгосон, мөн ажлын байрыг нэмэгдүүлэх ёстой байтал байнгын ажлын байртай иргэнд зээл олгосон, зээл хэлэлцэхээс өмнө зээлийн судалгааг СХС хариуцсан мэргэжилтэн объект дээр нь очиж судалгаа хийдэггүйгээс зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах явдал их байна. Тухайлбал:

- Дархан сумын иргэн Б.Цэвэлмаа нь Эмэгтэйчүүдийн ордны гүйцэтгэх захирал бөгөөд СХС-аас “Үсчний сургалт зохион байгуулах”-аар 14.0 сая, аймгийн ОНХС-ийн төсөл хөтөлбөрөөр 15.0 сая төгрөг давхар авсан.

- Дархан сумын 16 дугаар багийн иргэн Б.Оюун-Эрдэнэ 15 дугаар нутаг дэвсгэрт “Тахианы аж ахуй” эрхэлдэг бөгөөд СХС-аас “Шинэ өндөг” төслөөр 12.0 сая, 2013-2014 онд ЖДҮ-ийг дэмжих сангаас 600.0 сая төгрөгийн зээл авсан байлаа.

Түүнчлэн аж ахуйн нэгжид олгосон зээлээс зээлийн хэмжээ өндөр, хугацаа хэтрэлттэй төслийн хэрэгжилтийг сонгон шалгахад зохих ёсоор хэрэгжиж байв.

Төслийг үр дүнгүй, зориулалт бусаар зарцуулах, төслөө огт хэрэгжүүлэхгүй байх, дутуу гүйцэтгээд орхих зэрэг зөрчил дутагдлууд их байгаа ч зарим төсөл хэрэгжүүлэгч нар авсан зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байна. Тухайлбал:

Дархан сумын 16 дугаар багийн иргэн С.Болортуяа нь алслагдсан 15 дугаар багт шүдний эмнэлгийн салбараа нээн тоног төхөөрөмж авахаар 15.0 сая төгрөгийн зээлийг авч багийн иргэдэд хөнгөлөлттэй үнээр үйлчилж байна.



Дархан сумын 7 дугаар багийн иргэн Н.Баяртсайхан хүүхдийн цэцэрлэг тохижуулах төслөөр 14.0 сая төгрөгийн зээл авч хувийн цэцэрлэгийг тогтмол ажиллуулж, хүүхдийг тохь тухтай тохилог орчинд хүмүүжүүлж байна.



Шарын гол сумын иргэн Б.Сод-эрдэнэ тавилга үйлдвэрлэхээр 15.0 сая төгрөг авч сумын иргэдийг чанартай тавилгаар хангаж байна.



Мөн Шарын гол сумын Хайрхан багийн иргэн Мөнхболд нь 15,0 сая төгрөгийн зээл авч авто засвар, угаалга, оношилгоо, сэлбэгийн худалдааны чиглэлээр иргэдэд үйлчилж байна.




СХС-ийн орлого, зарлагын гүйцэтгэлийг шалгахад ЗДТГ-ын санхүүгийн программд бааз үүсгэн бүртгэж санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж байна.

Сум хөгжүүлэх сангаас Засаг даргын захирамжаар олгосон зээлийн дүн, шийдвэрийг болон сум хөгжүүлэх сангийн авлага, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг шилэн дансны албан ёсны сайтад сумд мэдээлээгүй байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,748.8 сая төгрөг, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 1,649.2 сая төгрөг байна.


/Сая төгрөг/



Сүүлийн 5 жилийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдлээр авч үзэхэд 2013 оны жилийн эцсийн байдлаар 1,478.5 сая төгрөгийн, 2014 оны жилийн эцсийн байдлаар 1,512.4 сая төгрөгийн, 2015 оны жилийн эцсийн байдлаар 1,707.4 сая төгрөгийн 2016 оны жилийн эцсийн байдлаар 1,758.7 сая төгрөгийн, 2017 оны жилийн эцсийн байдлаар 1,649.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Үүнээс харахад 2017 онд зээл, зээлийн хүүгийн авлага өмнөх оноос 109.5 сая төгрөгөөр буурсан байна.

СХС-ийн дэлгэрэнгүй тайлангаар аймгийн хэмжээнд 63 төсөлд 570.6 сая төгрөг олгосноос хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд 9 төсөл буюу 14.3 хувийг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлд 21 төсөл буюу 33.3 хувийг, мал аж ахуйн чиглэлд 23 төсөл буюу 36.5 хувийг, худалдааны чиглэлд 4 төсөл буюу 6.4 хувийг, бусад чиглэлд 6 төсөл буюу 9.5 хувийг олгосон байна.



Хүснэгтээс харахад сангийн хөрөнгийг бусад чиглэлд 6 төсөлд олгосон нь нийт төслийн 9.5 хувийг эзэлж байгаагаас зээлийг журмын зорилтод нийцэхгүй төсөлд олгожээ.

2.4 СХС-гийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан СХСХБЗТХТЖ-ын 3.3-д Сангийн үйл ажиллагааны талаар сумын ИТХ-ын хэрэгжүүлэх чиг үүргийг заасан. Сумдын ИТХурал нь шинэ журмыг хэрэгжүүлэн сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг болон сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг шинэчлэн байгуулжээ.

Сумын ИТХ-аар баталсан орон тооны бус зөвлөл байгуулсан боловч Дархан, Орхон, Хонгор сумдын зөвлөл нь СХС-гийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт шалгалт хийгээгүй. Харин сумдын ажил хариуцсан мэргэжилтнүүдийн хэрэгжүүлсэн шалгалтын тайлангаас дараах арга хэмжээг авч байжээ.

➤ Дархан сумын СХС-гийн зээл хариуцсан мэргэжилтэн нь хугацаа хэтэрсэн зээлийн түүхийг хөтлөж зээлдэгч бүртэй уулзсан, мэдэгдэл өгсөн мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэдэг байна. Зээлийн төлбөрийг хугацаандаа төлж байгаа ч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй 2 зээлдэгчийг төслийн мөнгийг эргэн татахаар 2017 онд шүүхэд шилжүүлж, эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

➤ Шарын гол сум нь СХС-гийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хийх хяналт шалгалтыг жил бүр үр дүнтэй хэрэгжүүлснээр хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт бусад сумтай харьцуулахад харьцангуй сайн байна.

СХС-ийн үйл ажиллагааны тайланг сан хариуцсан мэргэжилтэн журамд заасны дагуу улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг ИТХ-аар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байх ёстой боловч Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.3-т заасныг зөрчиж, сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийг жилийн эцэст л ИТХ-аар хэлэлцүүлсэн ч, хангалтгүй, иргэдэд мэдээлдэггүй байна.

Орон тооны бус хяналтын зөвлөл журмын дагуу ажиллаагүй, хяналт шалгалт хийсэн тайлан байхгүй, хяналт тавиагүйгээс журам зөрчигдөх, зээлийн үр дүн буурах, хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтрэх, зориулалт бусаар ашиглах нь өсөх хандлагатай байна.

2.5 “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын зарим заалтыг нарийвчлан тусгаж тодорхой болгох шаардлагатай байна.

СХС-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль болон “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай” зэрэг хууль тогтоомж, журам мөрдөгдөж байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг олгосноор орон нутагт санхүүгийн эрх мэдэл олгогдсон, арилжааны банкаар дамжуулахгүй олгож байгаа нь иргэдэд чирэгдэлгүй болсон, сумдын удирдлага жижиг дунд үйлвэрлэлийг дэмжих идэвхи сайжирч, иргэдийн санал санаачилга нэмэгдсэн, иргэд бие биедээ хяналт тавих нөхцөл бүрдсэн зэрэг давуу талууд бий болсон.

Суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих, тэдэнд бага хүүтэй банкны шаардлагаас гадуур зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэхээр олгосон зээл үр дүнгээ өгч байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын зарим заалтыг нарийвчлан тодорхой болгох шаардлагатай байна. Тухайлбал:

- Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн төсөл сонгон шалгаруулах орон тооны зөвлөлийг эдийн засгийн судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг бодитой хийж чадах мэргэжлийн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх, сонгон шалгаруулах үзүүлэлтүүдийг нарийвчлан зааж өгөх */Аудитын дүнгээс харахад Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг ижил чиглэлийн олон үйл ажиллагаанд хэт жижиглэн олгож байгаа нь жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өргөтгөхөд үр дүнгээ өгөхгүй байна/*
- Барьцаа хөрөнгийн гэрээний загвар, барьцаа хөрөнгө авч үлдэх талаар журамд нарийвчлан зааж өгөх.
- Журамд сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх ажилтны талаар тодорхой зааж өгөх */Сангийн санхүүгийн тайланг сумдын Санхүүгийн албаны дарга, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар гаргаж байгаа ч өдөр тутмын бүртгэлийг төдийлөн хийдэггүй, буруу хөтөлдөг, нэгдсэн чиглэл байдаггүй зэрэг зөрчил гарч байна/*

БҮЛЭГ 3

Өмнөх онуудад өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 100 хувь хэрэгжсэн байна.

3.1 Өмнөх оны Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжсэн байна.

Өмнөх онд хийгдсэн аудитаар ажил гүйцэтгэх гэрээний дагуу хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй, тохижилтын ажлаар хийгдсэн хөрөнгө баталгаат хугацаанд эвдэрч хэмхэрсэн зэрэгт холбогдох албан тушаалтнуудад 106.2 сая төгрөгийн зөвлөмж өгч, захиалагчийн хяналт тавих гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн Дархан-хот байгуулалт, барилга захиалагчийн газар ОНӨААТҮГ-ын хяналтын инженерт хариуцлага тооцох 1 албан шаардлага тус тус хүргүүлж ажилласан.

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХОХБТХ, ОНӨГ-аас зөвлөмжийн биелэлтийг албан тоотоор ирүүлсэн байдал, бидний хийж гүйцэтгэж буй нийцлийн аудитын дүн, сум орон нутагт ажиллаж, тулган баталгаажуулалт хийсэн дүн зэргээс харахад 2016 оны ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагаанд гарч байсан зөрчлүүд 100 хувь хэрэгжиж биелэгдсэн байна.

3.2 Өмнөх оны Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж хэрэгжсэн байна.

Аймгийн хэмжээнд 2014-2016 оны сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд хийсэн нийцлийн аудитаар нийт 81.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх 67.9 сая төгрөгийн 2, буцаан төвлөрүүлэх 13.7 сая төгрөгийн албан шаардлагууд өгөгдөж, хугацаандаа 100 хувь хэрэгжсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

1. 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг ОНХНС-аас хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос гадна гадаадын болон бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.
2. ОНХС-гийн хөрөнгө оруулалтыг аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөтэй уялдуулсан байна.
3. Нийт төсөл, арга хэмжээний хөтөлбөр, төслөөр хийгдсэн ажлуудын 23.2 хувь нь хэт жижиглэж олгосон нь төсөл хэрэгжихгүй, хэрэгжүүлсэн төсөл үр дүнгүй болох нөхцөлийг бүрдүүлж байна.
4. Дархан сум 4 хөтөлбөрт 18.9 сая төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн.
5. Аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооноос ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар

1. СХС-гаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд байнгын ажлын байр бий болоогүй байна.
2. Дархан сумын Засаг дарга сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн даргын эрхийг шилжүүлсэн байна.
3. СХС-ийн орон тооны бус зөвлөлийн хяналт, ИТХ, ЗД-ын үүргийн биелэлт хангалтгүй, ажлаа сумын ИТХ-д тайлагнадаггүй, зөрчил гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу явагдахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга С.Насанбатад зөвлөж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

1. Аймгийн ОНХС-гийн хэрэгжилтэд хяналт тавих Хяналтын хороог байгуулж, хяналт тавин ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах
3. Цаашид хэт жижиглэж олгох төсөл, хөтөлбөрийг зогсоох

Дархан сумын Засаг дарга Б.Азжаргалд:

1. Ашиглалтын зардлыг нь шийдвэрлээгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх
2. Ашиглагдахгүй байгаа хөрөнгийг ашиглалтад оруулах
3. Баталгаат хугацаандаа эвдэрч хэмхэрсэн, дутуу хийгдсэн 14.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг бүрэн хийж гүйцэтгүүлэх.

Сум хөгжүүлэх сангийн талаар

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга С.Насанбатад зөвлөж байна.

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн, үйл ажиллагаа явуулаагүй, чанаргүй төсөл сонгон шалгаруулсан, тэдгээрт зохих хяналт тавиагүй албан тушаалтанд хариуцлага тооцох талаар үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулах
2. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх ажлын тайланг хэлэлцүүлж, цаашид баримтлах чиглэлийг тодорхойлж шийдвэр гаргах

Сумдын Засаг дарга нарт зөвлөж байна.

1. Сангаас олгох зээлийн төсөлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан зээлдэгчийг сонгон шалгаруулж ажлын байр бий болгоход анхаарч ажиллах

2. Засгийн газрын “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллах

3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхижүүлэн чанаргүй зээлийн асуудлыг яаралтай шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2019 оны 05 дүгээр сарын 01-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР